

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ҮНДЭСЛЭЛ ЖУРАМ

№	Зөвшөөрөл	Үйлчилгээний төрөл	Холбогдох хууль, тогтоомж, журмын нэр зүйл заалт	Үндэслэл журам
1	Галт зэвсэг ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.10/	Үйл ажиллагаа эрхлэх хүсэлт /Иргэн/ Үйл ажиллагаа эрхлэх хүсэлт /ААН/ Үйл ажиллагаа эрхлэх хүсэлт /Иргэн/	Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 468, А/268 дугаар тушаалаар батлагдсан “Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум эзэмших, хадгалах журам”	ЗМТХ 5.2 дугаар зүйл. Зөвшөөрөл хүссэн өргөдөл шийдвэрлэх журам 1. Эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд өргөдлийг хүлээн авсан тухай зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэж, энэ тухай бүртгэлд тусгана. 2. Эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, дараах арга хэмжээ авна: 2.1. баримт бичгийн бүрдэл хангасан гэж үзвэл магадлан шалгах ажиллагааг эхлүүлэх; 2.2. өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол нөхөн бүрдүүлэх талаар зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэх; 2.3. өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэх. 3. Эрх бүхий этгээд энэ зүйлийн 2-т заасан арга хэмжээний талаар зөвшөөрөл хүсэгчид баримт бичгийн бүрдлийг шалгах хугацаанд багтаан мэдэгдэнэ. Нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг тус бүрийн талаар мэдэгдэлд тодорхой тусгана. 4. Энэ зүйлийн 2.2-т заасан баримт бичгийг нөхөн бүрдүүлэх хугацаа 30 хүртэл хоног байна. Энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол өргөдөл гаргаагүйд тооцно. 5. Зөвшөөрөл хүсэгч хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг эрх бүхий этгээд дараах хугацаанд магадлан шалгана: 5.1. тусгай зөвшөөрлийг ажлын 10 өдрийн дотор; 5.2. энгийн зөвшөөрлийг ажлын таван өдрийн дотор. 6. Эрх бүхий этгээд магадлан шалгах ажиллагаанд шаардлагатай нэмэлт мэдээлэл, лавлагаа, дүгнэлт, тодорхойлолт зэргийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.13-т заасны дагуу холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авна. 7. Магадлан шалгах ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагаас дүгнэлт, тодорхойлолт гаргуулах шаардлагатай бол энэ зүйлийн 5-д заасан хугацааг нэг удаа ажлын таван өдрөөр сунгаж болно. 8. Эрх бүхий этгээд магадлан шалгах ажиллагааг дууссанаас хойш ажлын таван өдөрт багтаан зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана. 9. Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоос татгалзсан бол мэдэгдэлд татгалзсан

				үндэслэлийг тодорхой заана. 10. Энэ зүйлийн 9-д заасан мэдэгдлийг мэдэгдэл гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор зөвшөөрөл хүсэгчид бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр хүргүүлнэ. /Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./
2	Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.11/	Үйл ажиллагаа эрхлэх хүсэлт /ААН/	Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын хамтарсан 2018 оны А/119, А/377 дугаар тушаалаар баталсан “Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”	“Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам” Нэг.Нийтлэг үндэслэл 1.1. Хувийн хамгаалалтын сургалт явуулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, бүртгэх,зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох, сургалтын үйл ажиллагаанд нь хяналт тавихад энэ журмыг мөрдөнө. 1.2.Хувийн хамгаалалтын сургалт явуулах иргэн, хуулийн этгээд Хувийн хамгаалалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, энэхүү журмыг баримтална. Хоёр.Хувийн хамгаалалтын сургалтыг бүртгэх, зөвшөөрөл олгох 2.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.3 дахь хэсэгт заасан мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загвар”-ын дагуу иргэн, хуулийн этгээд нь хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл авах баримт бичиг бүрдүүлнэ. 2.2.Иргэн, хуулийн этгээд нь хувийн хамгаалалтын сургалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.5 дахь хэсэгт заасан боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын дагуу бүртгүүлж, зөвшөөрөл авна. 2.3. Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд нь энэ тухайгаа цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ. Гурав.Хувийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт 3.1.Хувийн хамгаалалтын сургалт явуулах зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд нь үндсэн мэргэжлийн сургалтад элсэгч болон төгсөгчдийн нэрсийн жагсаалт, мэргэжлийн үнэмлэхийн нэгдсэн бүртгэлийн дугаарыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ. 3.2.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь хувийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналт тавина. 3.2.1. хувийн хамгаалалтын сургалт явуулах иргэн, хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж,зөвлөгөө өгөх;3.2.2. хувийн хамгаалалтын сургалтын

				үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд болон төгсөгчдийн талаар тоо бүртгэл хөтлөх;3.2.3.хувийн хамгаалалтын сургалтын агуулга, төлөвлөгөөнд санал өгөх; 3.2.4.хувийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт, үнэлгээ хийх, үр дүнг эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, тодорхойлолт өгөх; 3.2.5.хувийн хамгаалалтын сургалтад суралцагч нь урьд ял шийтгэл эдэлж байсан эсэхийг шалгах; 3.2.6.хувийн хамгаалалтын үндсэн мэргэжлийн сургалтын гэрчилгээ олгох шалгалтад оролцож, санал гаргах. Дөрөв. Бусад4.1.Хувийн хамгаалалтын сургалт явуулж байгаа иргэн, хуулийн этгээд үйл ажиллагааны тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.
3	Галт зэвсгийн гэрчилгээ олгох /Галт зэвсгийн тухай хуулийн 12.4/	Галт зэвсэг шилжүүлэх (Иргэн) Галт зэвсэг шилжүүлэх (ААН) "Галт зэвсгийн гэрчилгээ олгох (Шинээр олгох) "Галт зэвсгийн гэрчилгээ олгох (Сунгалт) "Галт зэвсгийн гэрчилгээ олгох (Нөхөж авах) Галт зэвсгийн гэрчилгээ олгох (ААН) (Шинээр олгох) Галт зэвсгийн гэрчилгээ олгох (ААН) (Сунгалт) Галт зэвсгийн гэрчилгээ олгох (ААН) (Нөхөж авах) Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл шинээр бүртгүүлж,	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-602, 603/ "Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох"	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 602. ГАЛТ ЗЭВСГИЙН БҮРТГЭЛ, ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭ ГАРГАХ 602.ГАЛТ ЗЭВСГИЙГ БҮРТГЭХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ 602.2.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Хууль зүйн сайдын 2015 оны А/219 дүгээр тушаалаар баталсан "Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам", мөн сайдын 2015 оны А/249 дүгээр тушаалаар баталсан "Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт", "Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл ашиглах журам", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/75 дугаар тушаалаар баталсан "Галт зэвсгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох журам", энэ журмыг мөрдлөг болгоно. 602.2.2. Хууль сахиулах албаны болон байлдааны /зэвсэгт хүчин, хил хамгаалах, тагнуулын байгууллагын/ зориулалттайгаас бусад галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн бүртгэл, хөдөлгөөний мэдээг цагдаагийн байгууллага гаргана. 602.3. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГАЛТ ЗЭВСГИЙГ БҮРТГЭХ 602.3.1. Галт зэвсэг худалдаж авах, өмчлөх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэгт зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд улсын хэмжээнд цагдаагийн төв байгууллагын Зөвшөөрөл, үйлчилгээний нэгж хариуцан зохион байгуулж, хяналт тавина 602.3.2. Орон нутгийн хэмжээнд галт зэвсэг эзэмших, өмчлөх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нэгж, нийслэлд иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгийг бүртгэх үйл ажиллагааг дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нэгж хариуцан зохион байгуулж, цагдаагийн төв байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон

		тодорхойлолт авах (иргэн)		нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Зөвшөөрөл, үйлчилгээний нэгж хяналт тавина. 602.3.3. Цагдаагийн төв байгууллагын Зөвшөөрөл, үйлчилгээний нэгж нь улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх хүсэлтийг хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор судалж, шийдвэрлэнэ. 602.3.4. Шүүх шинжилгээний байгууллага галт зэвсгээр буудсан сумны хонгио, хошуу тус бүрээс хоёрыг дээж болгон авч, тухайн галт зэвсэг болон түүнийг эзэмшигчийн талаарх мэдээллийг нэгдсэн санд бүртгэн оруулсан тухай мэдээллийг цагдаагийн төв байгууллагын Зөвшөөрөл, үйлчилгээний нэгжид даруй мэдэгдэнэ. 602.4. ГАЛТ ЗЭВСЭГ ӨМЧЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ 602.4.1. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, цагдаагийн төв байгууллагын Зөвшөөрөл, үйлчилгээний нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь Галт зэвсгийн тухай хууль тогтоомж болон энэ журмын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллана. 602.4.2. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийн тооллогыг Галт зэвсгийн тухай хуульд заасан хугацаанд цагдаагийн байгууллага явуулна. 602.4.3. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь галт зэвсэгтэй иргэн, хуулийн этгээдэд хэрхэн хяналт тавьж ажилласан талаарх мэдээг маягт (ЦБҮАЖ №602.43)-ын дагуу сар бүрийн 27-ны өдрийн дотор Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд ирүүлнэ.
		Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл шинээр бүртгүүлж, тодорхойлолт авах (ААН)		
		Галт зэвсгийн хамтран эзэмшигч бүртгүүлэх		
		Галт зэвсгийн хамтран эзэмшигч бүртгүүлэх ААН		
		Галт зэвсгийн гэрчилгээний хаягийн бүртгэл шилжүүлэх		
		Галт зэвсгийн гэрчилгээний хаягийн бүртгэл шилжүүлэх ААН		
4	Ан агнах, спорт-сургалтын зорилгоор галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр оруулах, гаргах, худалдан авах, /Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.8/	Монгол улсын иргэн галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл Уралдаан, тэмцээнд оролцох зорилгоор улсын хилээр галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах Хэрэгсэл оруулах, гаргах зөвшөөрөл (Иргэн) Уралдаан, тэмцээнд оролцох	Галт зэвсгийн тухай хуулийн 16.1, 16.2, 17, 20 дугаар зүйлийн 20.1, Хууль зүйн сайдын 2015.10.30-ны А/249-р тушаалын 2-р хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/74 дүгээр тушаал	Галт зэвсгийн тухай хуулийн 16 дугаар зүйл: “Галт зэвсэг, сум, импортлох, нийтэд худалдаалах”: 16.1. Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах хуулийн этгээд /цаашид "борлуулагч" гэх/ нь зургаан жилийн хугацаатай тусгай зөвшөөрөлтэй байна. Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгох бөгөөд тусгай зөвшөөрлийг сунгаж болно. 16.2. Сум импортлох, нийтэд худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг галт зэвсэг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл аваагүй этгээдэд сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгож болно. 16.3. Хууль зүйн, спорт, байгаль орчин, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тагнуул, цагдаа, гаалийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн комисс /цаашид "Комисс" гэх/ сонгон шалгаруулалтыг эрхлэн гүйцэтгэнэ. 16.4. Комиссын даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно. 16.5. Спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь

		зорилгоор улсын хилээр галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл оруулах, гаргах зөвшөөрөл (ААН)		өөрийн ажиллуулж байгаа буудлага үйлдэх байгууламж /тир/-д сум худалдаалах, импортлох эрхтэй байна. 16.6. Монгол Улсад галт зэвсэг, сум худалдах төв /цаашид "Төв" гэх/ ажиллуулах эрх улсын хэмжээнд гурваас илүүгүй хуулийн этгээдэд олгогдох бөгөөд Төв ажиллуулах эрхийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. 16.7. Борлуулагч энэ хуулийн 16.6-д заасан Төвд байрлан галт зэвсэг, сум худалдан борлуулна. Төв нь орон нутагт салбартай байж болно. 16.8. Борлуулагч галт зэвсэг, сум худалдан авагч иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг хуулбарлаж авна. 16.9. Тухайн жилд импортлох галт зэвсэг, сумны төрөл, зориулалт, тоо хэмжээг Комиссын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. 16.10. Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам, Төвд эрх олгох, салбар нээх журам, Төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 16.11. Борлуулагч нийтэд худалдах галт зэвсэг, сумыг тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд тээвэрлэх маршрут, хугацааг цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэнэ. Галт зэвсгийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Спортын тэмцээн, сургалт, ан агнуурын зориулалтаар галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх: 21.1. Иргэн улс, хот хооронд, орон нутагт агаарын хөлөг, хөлөг онгоц, галт тэрэг, бусад нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо галт зэвсэг авч явах бол галт зэвсгийг тухайн тээврийн хэрэгслийн дарга, эсхүл жолоочид хадгалуулна. 21.2. Энэ хуулийн 21.1-д заасан тээврийн хэрэгслийн дарга, жолооч нь галт зэвсгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцна. 21.3. Хот, суурин газарт, эсхүл нийтийн тээврийн хэрэгслээр галт зэвсгийг авч явахдаа гох, эсхүл замгийг цоожилж, сумыг тусад нь байлгаж, зориулалтын сав /хайрцаг/-нд хийн аюулгүй байдлыг ханган, галт зэвсгийн гэрчилгээний хамт авч явна. Хууль зүйн сайдын 2015.10.30-ны А/249-р тушаалын 2-р хавсралт, "Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл ашиглах журам": Нэг. Нийтлэг үндэслэл 1.1. Энэхүү журмын зорилго нь иргэн, хуулийн этгээд галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 1.2. Хууль сахиулах албаны зориулалтаар ашиглаж байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл энэ журамд хамаарахгүй 1.3. Иргэн, хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл ашиглахдаа Галт зэвсгийн тухай[1] болон Цагдаагийн албаны тухай[2] хууль, бусад хууль болон энэ
		Гадаад иргэн ан агнах зорилгоор Монгол улсын хилээр галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл оруулах, гаргах зөвшөөрөл		
		Нэг бүрийн тусгай хэрэгсэл гадаад улсаас оруулж ирэх зөвшөөрөл (Иргэн)		
		Нэг бүрийн тусгай хэрэгсэл гадаад улсаас оруулж ирэх зөвшөөрөл (ААН)		

				журмыг дагаж мөрдөнө. 1.4. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг иргэн ан агнах, спорт-сургалтын, үзмэр, цуглуулгын, хуулийн этгээд нь спорт-сургалтын, үзмэр, цуглуулгын болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор ашиглана. 1.6. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 1.6.1. “галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл” гэж Галт зэвсгийн тухай хуулийн 3.1.4-т заасныг; 1.6.2. “буудлага үйлдэх байгууламж /тир/” гэж Галт зэвсгийн тухай хуулийн 3.1.5-д заасныг; 1.6.3. “хийн буу” гэж шахсан хийн даралтын хүчээр сумаа /үрэл буюу хошуу/ харвадаг зэвсгийг; 1.6.5. “хавчаахай” /нумт буу/ гэж хөвчийг татаж сум харвах зэвсгийг. Хоёр. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэх 2.1. Энэ журмын 2.2-т зааснаас бусад галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг өмчлөх, эзэмших зорилгоор худалдаж авсан, улсын хилээр оруулсан иргэн, хуулийн этгээд ажлын 10 өдрийн дотор оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж бүртгүүлнэ. 2.1.1. иргэн бол иргэний үнэмлэхний, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 2.1.2. оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргын тодорхойлолт; 2.1.3. галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн эх сурвалжийг тодорхойлсон бичиг баримт. 2.2. Иргэн, хуулийн этгээд өмчлөх, эзэмших зорилгоор худалдаж авсан, улсын хилээр оруулсан хийн бууны гол төмрөөс хошуу буюу үрлийн шидэгддэг агшины кинетик энерги нь 7.5 жоулиас их, хавчаахай /нумт буу/ нь зэвт хошуу бүхий сумтай, нумны хөвчний татах хүч нь 43 кг-аас дээш бол иргэн, хуулийн этгээд оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж бүртгүүлнэ. 2.2.1. Галт зэвсгийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан шаардлага хангасан иргэн энэ хуулийн 12.1 дэх хэсэгт заасан баримт бичгийг; 2.2.2. хуулийн этгээд бол Галт зэвсгийн тухай хуулийн 12.3 дахь хэсэгт заасан баримт бичгийг. 2.3. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдан борлуулахаас өмнө тэдгээрийн нэр, төрөл, загвар, тоо ширхгийг тусгасан мэдээллийг цагдаагийн байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ. 2.4. Галт зэвсгийн тухай хуулийн 12.9 дэх хэсэгт заасны дагуу цагдаагийн байгууллага, шүүхийн шинжилгээний байгууллага нь нийтэд худалдах зорилгоор импортолсон, худалдсан, тээвэрлэсэн болон иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн гэрэл зураг, нэр, төрөл, загвар, сумны жин, тоо ширхгийг тусгасан мэдээллийн сантай байна.
--	--	--	--	---

				2.5. Цагдаагийн байгууллага гаалийн байгууллагаас ирүүлсэн улсын хилээр нэвтрүүлсэн галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн мэдээг тухай бүр мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулна. 2.6. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн мэдээллийн санг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд ашиглана. 2.7. Галт зэвсгийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө бүртгүүлээгүй галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг иргэн, хуулийн этгээд 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Нөхөн бүртгүүлж байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн эх үүсвэрийн талаар тайлбар шаардахгүй. Гурав. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг ашиглах 3.1. Галт зэвсгийн тухай хуулийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгүүлсэн зориулалтаар нь аюулгүй ажиллагааг ханган ашиглах эрхтэй. 3.2. Иргэн, хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг эзэмших, ашиглах тохиолдолд Галт зэвсгийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан ерөнхий шаардлагын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулна. 3.3. Хот, суурин газарт аюулгүй байдал хангасан буудлага үйлдэх байгууламж /тир/-д спорт-сургалтын буудлага, харваа хийж болно. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээд зориулалтын буудлага, харваа үйлдэх байгууламж /тир/-тай байна. 3.5. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалтад ороогүй галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах, эзэмших, өмчлөхийг хориглоно. 3.6. Иргэн, хуулийн этгээд нь галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэлийн гэрчилгээний хамт зориулалтын сав хайрцагт хийж, гохыг цоожилж, сумыг тусад авч явна. Энэ нь албан үүргээ гүйцэтгэж байгаа хамгаалалтын алба хаагч, байгаль хамгаалагчид хамаарахгүй. 3.7. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн зориулалт, бүтцийг өөрчлөхийг хориглоно. 3.8. Энэ жагсаалтад ороогүй, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд болон зориулалтын бусаар ашигласан, эрэн сурвалжлагдаж байгаа, үйлдвэрийн хийц, бүтцийг өөрчилсөн галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг эрх бүхий албан тушаалтан хураана. 3.9. Хураагдсан галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг Галт зэвсгийн тухай хуулийн 23.3 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ. Дөрөв. Бусад зүйл 4.1. Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг ашиглах журам зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
		Монгол улсын	Галт зэвсгийн	Галт зэвсгийн тухай хуулийн 16 дугаар зүйл “Галт зэвсэг, сум худалдаж авах”:

		иргэн гадаад улсаас галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдан авах хүсэлт	тухай хуулийн 16, 19 дугаар зүйл. 19.2	17.1. Иргэн, хуулийн этгээд борлуулагчаас галт зэвсэг худалдаж авах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр гаргана. 17.2. Цагдаагийн байгууллага энэ хуулийн 17.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан иргэнд иргэний үнэмлэх, энэ хуулийн 11.6-т заасан өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудсыг үндэслэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн зөвшөөрөл олгоно. 17.3. Борлуулагч энэ хуулийн 17.2-т заасан зөвшөөрлийг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд галт зэвсэг худалдана. 17.4. Борлуулагч галт зэвсэг эзэмших эрхтэй иргэн, хуулийн этгээдэд сум худалдах бөгөөд иргэн, хуулийн этгээдийн худалдан авсан сумны талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад ажлын гурван өдрийн дотор хүргүүлнэ. 17.5. Борлуулагч галт зэвсэг, сум худалдахдаа галт зэвсгийн тоо, төрөл, марк, дугаарын тэмдэглэл, сумны тоо ширхэг бүхий тодорхойлолтыг олгоно. 17.6. Борлуулагч галт зэвсэг, сумны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх бөгөөд бүртгэлийн загварыг цагдаагийн төв байгууллагын дарга батална. 17.7. Иргэн, хуулийн этгээд худалдаж авсан галт зэвсгээ энэ хуулийн 12.1, 12.3-т заасны дагуу бүртгүүлж галт зэвсгийн гэрчилгээ авна.
		Худалдан борлуулах төвөөс галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдан авах зөвшөөрөл (Иргэн)		Галт зэвсгийн тухай хуулийн 19 дүгээр зүйл “Галт зэвсэг, сум худалдаж авах”: 19.1. Энэ хуулийн 16.1, 16.2, 16.5-д заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 19.2. Галт зэвсэг өмчлөх эрхтэй Монгол Улсын иргэн өөрөө өмчлөх зорилгоор энэ хуулиар хориглоогүй нэг галт зэвсгийг жилд нэг удаа улсын хилээр оруулах эрхтэй. Иргэн өөрөө өмчлөх зорилгоор оруулж ирсэн галт зэвсгийг оруулж ирснээс хойш гурван жилийн дотор бусдад худалдах, бэлэглэхийг хориглоно. 19.3. Энэ хуулийн 19.2-т заасан галт зэвсгийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг олгох эсэхийг цагдаагийн байгууллага ажлын таван өдрийн дотор шийдвэрлэнэ. 19.4. Энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр оруулж болно. 19.5. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн спорт-сургалтын зориулалттай галт зэвсэг, сумыг спортын тэмцээнд оролцох, бэлтгэл хийх хэрэгцээнд зориулан улсын хилээр нэвтрүүлэх шийдвэр гаргана. /Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ 19.6. Энэ хуулийн 19.5-д заасан хүсэлтэд дараах мэдээллийг тусгана: 19.6.1. тухайн жилд болох тэмцээн, бэлтгэлийн төлөвлөгөө; 19.6.2. 19.6.2.галт зэвсэг, сумны тоо ширхэг; 19.6.3. тухайн гадаад улсын худалдаж байгаа байгууллагын тодорхойлолт.
		Худалдан борлуулах төвөөс галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдан авах зөвшөөрөл (ААН)		

				19.7.Энэ хуулийн 19.6-д заасан галт зэвсэг, сумыг нийтэд худалдахгүй бөгөөд зөвхөн спорт-сургалтын зориулалтаар спортын тэмцээнд оролцох, бэлтгэл хийх хэрэгцээнд ашиглана.		
5	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх /Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.1/	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрөл	Уур уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайд, ЦЕГ-ын дарга нарын хамтарсан 2023.07.04-ний А/246, А/189 дүгээр тушаалаар баталсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам”	Нэг. Нийтлэг үндэслэл 1.1. Монгол Улсын хэмжээнд олон улс, улсын, орон нутгийн чанартай авто зам, нийслэлийн, тусгай зориулалтын, аж ахуй нэгж, байгууллагын дотоодын авто зам, талбайд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна. 1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Автотээврийн тухай, Автозамын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох стандарт, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгоно. 1.3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон түүний үндсэн түүхий эдийг тээвэрлэх ажиллагааг улс хоорондын тээвэрлэлт, хот хоорондын тээвэрлэлт, орон нутгийн тээвэрлэлт, ажлын байран дахь тэсрэх материалын тээвэрлэлт гэж ангилна. 1.4. Улс хоорондын тээвэрлэлт, хот хоорондын тээвэрлэлт, орон нутгийн тээвэрлэлтийг энэхүү журмын 6.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлд тус тус зааснаар баталсан маршрутын дагуу тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, дотоодын цэргийн алба хаагчтай хамт гүйцэтгэнэ. 1.5. Ажлын байран дахь тэсрэх материалын тээвэрлэлтийг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу гүйцэтгэнэ. 1.6. Засгийн газрын тогтоолоор баталсан "Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах журам"-д зааснаар үзвэрийн пиротехникийн хэрэгслийг энэ журмын 3.1, 4 дүгээр зүйл, 7.2, 8.8, 8.10 дахь хэсэг, 11 дүгээр зүйлд заасныг баримталж, хэрэглээний пиротехникийн хэрэгслийг галын аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж тус тус тээвэрлэнэ. Хоёр. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хамтатгах бүлгийн ангилал болон дэд ангийн ангилал Тэсрэх материалын хамтатгах бүлгийн ангилал		
		Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэлтийн маршрут		Хамтатгах бүлэг /аюулын зэрэг/	Бодис, бүтээгдэхүүн	
					В	Өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр хүртэл үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн. Түүнчлэн ердийн детонатор, детонатор агуулсан хэрэгсэл ба өдөөгч тэсрэх бодис агуулаагүй детонаторууд орно.

				C	Шидэх үйлчилгээтэй тэсрэх бодис ба бүтээгдэхүүн (утаагүй дарь)
				D	Тэсрэх бодис. Тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй тэсрэх бодис бүхий бүтээгдэхүүн. Өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр ба түүнээс дээш тооны үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн.
				E	Тэсэлгээний хэрэгсэлгүй тэсрэх бодис агуулсан, гэхдээ шидэх үйлчилгээтэй цэнэг бүхий бүтээгдэхүүн (хялбархан дөл авалцдаг шингэн, гель буюу өөрөө шатдаг шингэнээс бусад)
				F	Хоёрдогч тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулсан, эсвэл шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй бүтээгдэхүүн
				G	Пиротехникийн бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүн
				N	Мэдрэмтгий чадвар нь онцгой муу тэсрэх бодис агуулсан бүтээгдэхүүн
				S	Гаднын гэнэтийн үйлдлээс цочрол авч тэсрэх аюул тохиолдоход түүний үйлчилгээг хязгаарлах сав, баглаа боодолтой, хэрэв сав баглаа нь галд өртөж гэмтвэл тэсрэлтийн нөлөө цацалт нь аваар устгах, гал унтраахаар сав баглааны дэргэд хүн ажиллахад саад болохгүйгээр тусгайлан бүтээгдсэн бодис, бүтээгдэхүүн
				ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН ДЭД АНГИЙН АНГИЛАЛ	
				Дэд анги	Дэд ангийн нэр
				1.1	Бөөнөөр тэсрэх аюултай тэсрэх материалууд
				1.2	Бөөнөөр тэсрэхгүй, гэхдээ тэсрэлтээр цацалт үүсгэх болон орчны зүйлийг гэмтээх аюултай тэсрэх материалууд
				1.3	Бөөнөөр тэсрэхгүй, шатах аюултай тэсрэх материалууд
				1.4	Тээвэрлэлтийн явцад гал гарах буюу өдөөсөн тохиолдолд бага зэргийн тэсрэлтийн аюултай тэсрэх материал. Тэсрэлтийн үйлчлэл нь сав баглаагаар хязгаарлагдана. Гаднын өдөөх эх үүсвэр сав баглаа дотор огцом тэсрэлт үүсгэхгүй.
				1.5	Бөөнөөр тэсрэх аюултай, гэхдээ мэдрэмтгий чадвар нь маш бага, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлд өдөөлт үүсэх ёсгүй буюу шаталтаас тэсрэлтэд шилжихгүй тэсрэх материалууд
				1.6	Тохиолдлын өдөөлтөд өртөх магадлал багатай, бөөнөөр тэсрэхгүй, нэн бага мэдрэх чадвартай тэсрэх бодисоор хийсэн бүтээгдэхүүн. 1.6 дэд ангийн бүтээгдэхүүний аюул нь нэг бүтээгдэхүүний тэсрэлтээр хязгаарлагдана.

				Гурав. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэлтэд бэлтгэх, түүний сав, баглаа боодолд тавих шаардлага Гурав. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэлтэд бэлтгэх, түүний сав, баглаа боодолд тавих шаардлага 3.1. Ачаа илгээгч нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг аюулгүй, бүрэн бүтэн, тээвэрлэхэд тохиромжтой байдлаар бэлтгэнэ. Үүнд: 3.1.1. сав, баглаа боодол, уут хайрцаг дээр үйлдвэрлэсэн, импортолсон байгууллагын нэр, хаяг, утасны дугаар, бүтээгдэхүүний нэр, энэ журмын хүснэгт 1, 2-т заасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюултай байдлын бүлгийн ангилал, дэд ангилал тус бүрийг байрлуулсан, битүүмжлэлтэй, лацадсан байх; 3.1.2. сав, баглаа боодол доторх тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь нягт чигжигдсэн, сул чөлөөтэй хөдөлгөөнгүй байх. 3.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сав, баглаа боодол, уут хайрцгийг дараах нөхцөлд аюулгүй ачааны адил тээвэрлэхийг зөвшөөрнө. Үүнд: 3.2.1. сав, баглаа боодол, уут хайрцгийг нэг бүрчлэн шалгаад "Сав, баглаа боодол бүрэн цэвэрлэгдсэн. Аюулгүй" гэсэн тэмдэглэл хийгдсэн байх; 3.2.2. хуулийн этгээдийн тэмдэг, шалгасан огноотой, үзлэг хийсэн ажилтны гарын үсэгтэй байх. Дөрөв. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавих шаардлага 4.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тусгай зориулалтаар үйлдвэрлэсэн, эсхүл үйлдвэрлэгчээс тогтоосон нөхцөл шаардлагад нийцүүлэн тоногдсон, зөвшөөрөл олгогдсон, авто тээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан, шингэн түлшээр ажилладаг тээврийн хэрэгсэл болон чиргүүлээр тээвэрлэнэ. Тээврийн хэрэгсэл нь үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний нөөц, гүйлт хэтрээгүй байх бөгөөд дараах шаардлагад нийцүүлэн тоногдсон байна. Үүнд: 4.1.1. тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарч байгаа утааны яндан оч баригчтай байхаас гадна шатахууны сав /нөөц/-наас алслагдсан байх; 4.1.2. тээврийн хэрэгслийн тэвшний хана, шал нь үрэлтээс оч үүсэхгүй галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх; 4.1.3. тээврийн хэрэгслийн шатахууны савны хойд ба урд хэсэгт нь төмөр хаалтаар тоноглож, доод талаас нь 10х10 мм нүх бүхий төмөр тороор хамгаалсан байх бөгөөд хамгаалалт болон түлшний савны хоорондох зай 20 мм-ээс багагүй зайтай байх; 4.1.4. түлшний сав нь хөдөлгүүр, цахилгааны утаснууд, утааны яндангаас хол байрлах ба хэрвээ шатахуун гоожих тохиолдолд шууд газарт асгарахаар байрласан байх; 4.1.5. тээврийн хэрэгслийн цахилгааны тоног төхөөрөмжүүдийн хүчдэл нь 24 вольтоос ихгүй, цахилгааны хэлхээ нь гал хамгаалагчаар бүрэн хамгаалагдсан,
--	--	--	--	--

				хэлхээний бүх хүчдэлийг салгах боломжтой байдлаар тоногдсон байх ба үйлдвэрлэгчээс тухайн тээврийн хэрэгсэлд цахилгаан хэлхээний хүчдэл салгах тоноглол байршуулсан бол зориулалтыг өөрчлөхгүй; 4.1.6. тээврийн хэрэгсэлд холбоо мэдээллийн хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд сансрын холбооны хэрэгсэл, байршил тогтоогч GPS төхөөрөмж, тээвэрлэх явцад автомашины бүхээг доторх болон явж байгаа маршрутын замын бичлэг хийх камер суурилуулсан байх ба бичлэгийг тухайн хуулийн этгээд тээвэрлэлт дууссанаас хойш зөрчил илрээгүй тохиолдолд ажлын 7 хоногийн хугацаанд хадгалж, нууцлал аюулгүй байдлыг хангах ба ажлын байранд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгсэлд байршил тогтоогч буюу GPS төхөөрөмж суурилуулахыг шаардахгүй; 4.1.7. битүүмжилсэн тэвш нь галд тэсвэртэй, бат бөх материалаар хийгдсэн, хаалга нь бат бөх, цоожлох боломжтой байх ба битүүмжилсэн тэвшний хаалга онгойсон тохиолдолд дохио өгөх систем байрлуулсан байх. 4.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд: 4.2.1. жолоочийн бүхээгийн дээр шар гэрэл болон тэвшний хойд талын баруун, зүүн дээд өнцөгт шар гэрэл ойлгогч байрлуулах; 4.2.2. нөөц дугуй 1-2 ширхэг, дугуйны хэмжээнд таарсан 2-оос доошгүй өнхрөхөөс сэргийлсэн ивүүртэй байх; 4.2.3. ашиглалтын хугацаа дуусаагүй галын хор (нунтаг хор болон 5 л-ээс багагүй эзлэхүүнтэй нүүрс хүчлийн хий) хоёроос доошгүй, гал унтраах цохиур, галд тэсвэртэй бүтээлэгтэй байх; 4.2.4. засвар үйлчилгээ хийх иж бүрэн багаж түлхүүр, гулгалтаас хамгаалах гинжтэй байх; 4.2.5. эмийн сан, шүгэл, улаан өнгө бүхий анивчих гэрэлтэй байх; /гар чийдэн/ 4.2.6. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан "Ослын зогсолтын тэмдэг", "Орох хориотой" тэмдэг тус бүр 2 ширхэг байх. 4.3. хуулийн этгээд нь энэхүү журмын 1.3 дахь хэсэгт заасан тээвэрлэлтэд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх үндсэн болон нөөц тус бүртээ 2-оос доошгүй, ажлын байранд тэсрэх материал тээвэрлэх 2-оос доошгүй тээврийн хэрэгсэлтэй байна. 4.4. хуулийн этгээдээс тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон түүний үндсэн түүхий эдийг улс хооронд, хот хооронд, орон нутагт тээвэрлэх тээврийн хэрэгслийг техникийн үзлэг оношилгоонд оруулж тэнцсэн тохиолдолд жилд 2 удаа, ажлын байранд тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгслийг жилд 1 удаа авто тээврийн хяналтын улсын байцаагчийн аюултай ачаа тээвэрлэх стандарт шаардлага хангасан талаарх дүгнэлтийг гаргуулж цагдаагийн байгууллагын бүртгэл хяналтын ажил хариуцсан нэгжид хүргүүлнэ. 4.5. хуулийн этгээд нь авто тээврийн хэрэгслийг хадгалах зориулалтын зогсоол,
--	--	--	--	---

				талбайтай байх бөгөөд засвар үйлчилгээний ажлыг хариуцсан инженер, механик, засварчинтай байна. Дээрх засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно. 4.6. Цагдаагийн байгууллагын бүртгэл хяналтын ажил хариуцсан нэгж нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн талаарх мэдээллийг нутаг дэвсгэр хариуцсан байгууллагад тухай бүр нь мэдэгдэнэ. Тав. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх жолоочид тавигдах шаардлага 5.1. Тухайн ангиллын тээврийн хэрэгслийг 3-аас дээш жил тасралтгүй жолоодсон, тухайн ангилалд тохирох, аюултай ачаа ачих чиглэлээр мэргэшсэн жолоочийн хүчинтэй үнэмлэхтэй, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрмийн 16-д заасны дагуу тэсрэх материалтай харьцаж ажиллах эрх олгох сургалтад хамрагдаж, үнэмлэх авсан хүн байна. 5.2. Жолооч нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан бичиг баримтыг авч явахаас гадна дараах тээвэрлэлтийн бичиг баримттай байна. Үүнд: 5.2.1. ачаа илгээгчээс хүлээн авагчид хүлээлгэн өгөх тээврийн хэрэгслийн явах зам, хурд, хоноглох, түр зогсолт хийх, шатахуун цэнэглэх газар, ачааны нэр төрөл, тоо хэмжээ зэргийг тогтоосон тээвэрлэлт зохион байгуулалтыг төлөвлөсөн бүдүүвч зураг буюу "Тээвэрлэлтийн маршрут"; 5.2.2. тухайн тээврийн хэрэгслээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрөл; 5.2.3. тээвэрлэж яваа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ослын карт. 5.3. Жолооч автомашины техникийн бүрэн бүтэн байдал, ачааны татлага, лац ломбо болон тэвшний хаалга хаалтуудад бүрэн хяналт тавина. 5.4. Найман цагаас дээш завсарлагагүй хугацаагаар тээвэрлэлтийн ажил гүйцэтгэх ба энэхүү журмын 1.3 дахь хэсэгт заасан тээвэрлэлтэд ээлжийн жолоочтой байна. 5.5. Зайлшгүй зогсолт хийх тохиолдолд ачаа илгээгч болон хүлээн авагч байгууллагад шуурхай мэдэгдэж, суурин газраас 200 метрээс багагүй зайд, замын баруун гар талыг шахаж, хойно ба урдаа 100 метрийн зайд "Ослын зогсолтын тэмдэг" тавина. 5.6. Зам тээврийн осол гарсан тохиолдолд тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, дотоодын цэргийн алба хаагч, жолооч Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм болон ослын картад заасны дагуу шуурхай ажиллах ба шаардлагатай гэж үзвэл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: 5.6.1. онцгой байдал болон эмнэлгийн түргэн тусламж дуудах, зам тээврийн осол, хэргийн газар руу гаднын хүмүүсийг ойртуулахгүй байх бүхий л арга хэмжээ авах; ослын аюултай бүсийг тэмдэглэн зааглаж бусад хүмүүс осолд нэрвэгдэхээс сэргийлэх;
--	--	--	--	--

				5.6.3.цагдаа, эмнэлэг болон бусад албаны ажилтнуудыг ирэх үед тээврийн баримт бичгээ шалгуулах, тээвэрлэж яваа ачааны хор хөнөөл, шинж байдал, ачаатай хэрхэн харьцах нөхцөлийн талаар бүрэн танилцуулах. Зургаа. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн маршрут ба тээвэрлэх хуудас 6.1.Хуулийн этгээд нь энэхүү журмын 5.2.1-д заасан тээвэрлэлтийн маршрутыг нөөц маршрутын хамт боловсруулан 24 цагийн өмнө цагдаагийн байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгжид хүргүүлж батлуулна. Тээвэрлэлтийн маршрутыг боловсруулахдаа дараах нөхцөлийг тооцож үйлдэнэ. Үүнд: 6.1.1.хот суурин газар, үйлдвэрийн объект, эмнэлэг, сургууль, олон нийтийн газар, байгалийн хамгаалалттай бүс, түүх соёлын дурсгалт газруудыг аль болох дайран өнгөрөхгүй байх; 6.1.2.батлагдсан хатуу хучилттай, сайжруулсан, ердийн хөрсөн замыг сонгож хөдөлгөөн үйлдэх бөгөөд ямар замаар явах, хаана зогсож хоноглох, хооллох, шатахуун цэнэглэх, замын аль хэсэгт аюултай, анхааралтай явах хэсэг байгаа эсэхийг; 6.1.3.төв суурин газруудыг аль болох тойрч гарах чиглэлийг сонгох бөгөөд зайлшгүй тохиолдолд суурин газар дайрч өнгөрөх бол цувааг суурин газар орохоос өмнө тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэст хамгаалалт авах цаг хугацаа, зогсох цэг зэргийг. 6.2. Цагдаагийн байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай хамгаалалтын гэрээ байгуулсан хуулийн этгээдээс боловсруулж, илгээсэн тээвэрлэлтийн маршрутыг хянаж батлах бөгөөд мэдээлэл зөрүүтэй, дутуу оруулсан, даац, жин зөрүүтэй, бичиг баримт зөрчилтэй, тухайн хуулийн этгээдэд бүртгэлгүй тээврийн хэрэгслийн мэдээлэл оруулсан бол зөрчлийг арилгуулахаар татгалзаж буцаана. 6.2.1. тэсрэх бодисын үндсэн түүхий эдийг зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр, маршрут батлуулан, дотоодын цэргийн хамгаалалт авахгүй тээвэрлэхийг зөвшөөрнө. 6.2.2. Эрдэм шинжилгээний сорилт, туршилт хийх зориулалтаар дээж авч явах тохиолдолд энэхүү журамд заасан шаардлагыг хангаж тээвэрлэнэ. 6.3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэх тоо хэмжээг тогтоосон "Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас"-ыг Геологи, уул уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Салбарын хяналтын газраас цаасан болон цахим хэлбэрээр тухай бүр олгоно. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлнэ.Үүнд: 6.3.1. Геологи, уул уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Салбарын хяналтын газраас олгосон "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас"; 6.3.2.тэсэрч дэлбэрэх бодис,
--	--	--	--	--

				тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэх тоо хэмжээг заасан албан хүсэлт; 6.3.3.цагдаагийн байгууллагаар батлуулсан "Тээвэрлэлтийн маршрут". 6.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэх хуудас нь бичигдсэн болон цахим системд баталгаажсан өдрөөс эхлэн ажлын таван өдрийн дотор хүчинтэй байх бөгөөд хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд тээвэрлэх хуудсыг дахин авна. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэх хуудсыг цахим системээр олгох тохиолдолд "QR" кодоор баталгаажуулна. 6.5. Тээвэрлэлтийн үед давагдашгүй хүчин зүйл тохиолдох, цаг агаар, замын нөхцөл байдлаас шалтгаалж тухайн маршрутад заасан замаар тээвэрлэлтийг цааш үргэлжлүүлэх боломжгүй тохиолдолд нөөц маршрутаар явна. 6.6 Хуулийн этгээд нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, технологийн горимын биелэлтэд дотоод хяналт тавих нэгж, албан тушаалтантай байх бөгөөд үйл ажиллагаандаа хяналт тавьж ажиллах үүрэг хүлээнэ. Долоо. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн хэрэгсэлд ачих ба буулгах 7.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн хэрэгсэлд ачих, буулгахдаа зориулалтын талбайд "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийг баримтлан гүйцэтгэнэ. 7.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн хэрэгсэлд хайрцаг савыг сул зай гаргахгүй, хоорондоо мөргөлдөхгүй, тэвшний хана, шаланд цохигдохгүй, үрэгдэхгүй, унахгүй байхаар байрлуулж ачна. 7.3. Ачаа илгээгч нь Геологи, уул уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Салбарын хяналтын газраас олгосон "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас", цагдаагийн байгууллагын баталсан "Тээвэрлэлтийн маршрут"-ыг үндэслэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олгоно. 7.4. Ачаа илгээгч нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээ, лац ломбо, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг нэг бүрчлэн шалгаж тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтанд хүлээлгэж өгнө. 7.5. Ачиж буулгах үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн мөрддөг аюулгүй ажиллагааны зааврын дагуу явагдана. Ачаа ачуулсан машин үйлдвэр-агуулахын талбайгаас гарч тусгай зориулалтын хамгаалалттай талбайд байрлана. Ачаа ачуулах дараагийн машин ачилт, буулгалтын талбайгаас 100 метрээс хол зайд байрлаж хүлээнэ. 7.6. Ачаа ачиж буулгах үед жолооч нь тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтрааж, зогсоолын торомз татаж, хоёр талын дугуйнд ивүүр хийн, бүхээгээс бууж, аюулгүй байдлыг хангана. 7.7. Ачааг хоёр болон түүнээс дээш хүлээн авагчид нэг удаагийн тээвэрлэлтээр хүргэх бол тэдгээрийг зааглан бэхэлж, тус тусад нь ачиж буулгана.
--	--	--	--	--

				Найм. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед тавих шаардлага 8.1.Тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, дотоодын цэргийн алба хаагч, жолооч нар ачааныхаа шинж байдал онцлог нөхцөл байдлыг мэдсэн байх шаардлагатайгаас гадна болзошгүй ослын үед хувийн хамгаалах хэрэгслүүдийг ашиглах, анхны тусламж үзүүлэх чадвартай байна. 8.2. Тээвэрлэлтийн хамгаалалт авах хүсэлтийг тээвэрлэлт хийхээс 48 цагийн өмнө албан бичгээр дотоодын цэргийн байгууллагад ирүүлнэ. Дотоодын цэргийн байгууллага нь тээврийн хэрэгслийн тоо, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэмжээ, аюулгүй байдлыг харгалзан тээврийн хамгаалалтад ажиллах алба хаагчийг томилно. 8.3. Дотоодын цэргийн алба хаагч нь тээврийн хэрэгсэлд ачиж, лацадсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хуулийн этгээдээс лацаар нь хүлээн авч, лацаар нь хүлээлгэн өгнө. Хэрэв лац хөндөгдсөн тохиолдолд өөрийн дээд шатны удирдах дарга болон хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж тэмдэглэл үйлдэж, бусад нотлох баримтыг бүрдүүлэн зөрчлийг арилгуулна. 8.4. Нэг тээврийн хэрэгслээр тээвэрлэж яваа нөхцөлд тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан болон дотоодын цэргийн алба хаагч нар хамт явж болох бөгөөд хоёр, түүнээс дээш тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа үед тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан цувааны эхний машинд, дотоодын цэргийн алба хаагч сүүлийн автомашинд явж, хоорондоо холбогдох холбооны хэрэгсэлтэй байна. 8.5. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл нь шатахуунаар хүрэлцэхүйц цэнэглэгдсэн байна. Зайлшгүй шаардлагаар зам зуур шатахуунаар цэнэглэх нөхцөлд хот, суурин газрын захад байрласан маршрутад тусгагдсан шатахуун түгээх станцаас цэнэглэж болно. 8.6. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийн хурдыг хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгсэл болон тээж яваа ачааны онцлог, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд тогтоосон хурдны хязгаараас хэтрүүлэхгүйгээр тохируулан сонгож явна. 8.7. Тав болон түүнээс илүү тооны автомашинууд цуваагаар тээвэрлэх тохиолдолд цувааны урд заавал хамгаалалтын хөтөч автомашин, цувааны сүүлд нөөц /засварын/ тээврийн хэрэгсэл заавал явна. Хамгаалалтын хөтөч автомашин болон цуваанд яваа тээврийн хэрэгслүүд нь ойрын гэрлээ асааж явна. 8.8. Аянга цахилгаантай бороотой үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсооно. Ингэхдээ тээврийн хэрэгслийг ой мод, уулын хавцал, жалга болон хот суурин газраас 200 метр, машин хооронд 50 метрээс багагүй зайд байрлуулж, жолооч болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан, дотоодын цэргийн алба хаагч нь тээврийн хэрэгслийг 200 метрээс багагүй зайнаас хянана. 8.9.Тээврийн
--	--	--	--	---

				хэрэгслийн хойно ба урд талд тэсрэх материалын ангилал, дэд ангилал, НҮБ-ын аюултай ачааны код бүхий "Аюултай ачаа тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл" таних тэмдгийг Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3 дугаар хавсралтад заагдсаны дагуу байрлуулна. 8.10. Тээвэрлэлтийн үед дамжин өнгөрч байгаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хяналтын цэгт бүртгүүлж, цагдаагийн алба хаагч хяналт тавих бөгөөд тээвэрлэлтийн үйл ажиллагааг хариуцсан ажилтан болон дотоодын цэргийн алба хаагч энэ талаар бүртгэл хөтөлнө. 8.11. Тэсрэх материалын тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэхтэй байх ба түүний овог, нэр, албан тушаалыг замын хуудас дээр тэмдэглэсэн байна. Тэсрэх материалын тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан тэсрэх материалын тээвэрлэлтийг ачихаас буулгах хүртэлх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна. 8.12. Эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын ажилтны шаардлагаар тээвэрлэлт саатсан тохиолдолд энэ талаар хяналт шалгалт хийсэн албан тушаалтнаар тэмдэглэл хийлгэж баталгаажуулна. Ес. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн ослын карт 9.1. Тээвэрлэлтийн үед тээвэрлэж буй ачааны онцлог шинж чанар, хор хөнөөлт байдал, тээвэрлэлтийн явцад тохиолдож болох эрсдэл, аюул ослын үед авах хариу арга хэмжээ, шаардлагатай үед тусламж дуудах утасны дугааруудыг тусгасан мэдээлэх хуудас /маягт №2/ бүхий тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн ослын карт /цаашид "Ослын карт" гэх/-тай байна. 9.2. Ослын картыг ачаа илгээгч байгууллага бөглөж ачааны зарлагын баримттай хамт тээвэрлэлтийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан болон тээврийн хэрэгслийн жолоочид хүлээлгэн өгнө. 9.3. Ослын карт дээрх яаралтай арга хэмжээ авах тоон кодууд нь НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан зааварт заасны дагуу тавина. 9.4. Тээвэрлэлтийн үед осол гарсан тохиолдолд ослын картад заасан ослын нөхцөлд зайлшгүй авах арга хэмжээнүүдийг яаралтай авч хэрэгжүүлнэ. Арав. Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох 10.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох, сунгах харилцааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7.1 дэх заалтыг үндэслэн цагдаагийн байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж олгоно. Хуулийн этгээдээс зөвшөөрөл хүсэхдээ шаардлага хангасан дараах бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд: 10.1.1. зөвшөөрөл хүссэн албан бичиг; 10.1.2. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 10.1.3. үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хуулбар; 10.1.4. тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэх; 10.1.5. аюултай ачаа ачих болон тухайн ангилалд тохирох мэргэшсэн
--	--	--	--	--

				жолоочийн хүчин төгөлдөр үнэмлэх; 10.1.6. тэсрэх материалтай харьцаж ажиллах эрхийн үнэмлэх ; 10.1.7. эрүүл мэндийн үзлэгийн хуудас; 10.1.8. автотээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар; 10.1.9. тээврийн хэрэгслийг стандартын дагуу тусгайлан тоноглогсон тухай хуулийн этгээдийн тодорхойлолт, уг тээврийн хэрэгслийг 4 талаас нь авсан фото зураг; 10.1.10. автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоонд орж тэнцсэн дүгнэлт; 10.1.11. автотээврийн хяналтын улсын байцаагчийн аюултай ачаа ачих стандарт шаардлага хангасан тухай дүгнэлт; 10.1.12. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах талаар аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн талаар нотломж; 10.1.13. автотээврийн хэрэгслийн албан татвар төлсөн тухай нотломж; 10.1.14. жолоочийн хариуцлагын даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдсан нотломж; 10.1.15. энэ журмын 4.1, 4.2-т заасан тээврийн хэрэгсэлд тавих шаардлага, тээврийн хэрэгслийн иж бүрдлийг шалгасан тухай нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын тодорхойлолт; 10.1.16.хуулийн этгээд нь болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө батлуулсан байна; 10.1.17 хуулийн этгээд энэ журмын 4.3, 4.4, 4.5, 6.6 дахь нөхцөл шаардлагыг хангасан талаар нотломж, баримт бичиг. 10.2 Цагдаагийн байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж нь хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч магадлаад энэхүү журмын 10.1-д заасан бичиг баримтын бүрдлийг хангасан тохиолдолд зөвшөөрөл /маягт №1/-ийг олгоно. 10.3.Энэ журмын 10.2-т заасан зөвшөөрөл /маягт №1/ Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалтад заасан мэдээллийг тусгасан байна. 10.4. Тээврийн хэрэгслийн зөвшөөрөл нь 3 жилийн хугацаатай байх ба тухайн тээврийн хэрэгслийн гэрчилгээний хамт хүчинтэй байна. 10.5. Энэ журмын 10.1-д заасан бичиг баримт, нотломжийг дутуу ирүүлсэн, мэдээллийн санд мэдээллээ дутуу илгээсэн тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, хариуг албан бичгээр өгнө. 10.6. Цагдаагийн байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж нь зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс тээвэрлэлтийн аюулгүй ажиллагаа зөрчсөн, батлагдсан маршрутаас гадуур, зөвшөөрөлгүй тээвэрлэлт хийсэн, тайлан мэдээ, баримт бичиг, нотломжийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг үндэслэн зөвшөөрлийн хүчингүй болгож мэдэгдэнэ. 10.7. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл бий болсон тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх хэсгүүдийг тус тус баримтлан шийдвэрлэнэ.
--	--	--	--	--

				Арван нэг. Хориглох зүйл 11.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах зүйлийг хориглоно. Үүнд: 11.1.1. тэсэрч дэлбэрэх бодисыг тэсэлгээний хэрэгслийн хамт тээвэрлэх; 11.1.2. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг өөрөө буулгагч тээврийн хэрэгслээр тээвэрлэх; 11.1.3. тусгайлан тоноглогдоогүй, зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх; 11.1.4. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх үед тээврийн хэрэгслийн орчимд тамхи татах, тээврийн хэрэгслээс 100 метрээс ойр зайд ил гал гаргах; 11.1.5. тусгай зориулалтын хатуу холбоогоор холбогдоогүй чиргүүлээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх; 11.1.6. жолооч нь энэхүү журмын 6.5-д заагдсан нөхцөлөөс бусад тохиолдолд батлагдсан маршрутыг зөрчих, өөр газарт зогсолт хийх, хурд хэтрүүлэх; 11.1.7. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэлд өөр төрлийн ачаа ачих, уг ачаатай хамааралгүй хүн авч явах; 11.1.8. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг цахилгаан дамжуулах шугамын доор, төмөр замын гарам, гүүрний дээр болон доор, туннел дотор, суурин газар зогсох болон зориулалтын бус гараж түүнтэй адилтгах барилга байгууламж дотор болон зогсоолд тавих; 11.1.9. амархан шатах материалаар хийгдсэн татлага буюу хучлагыг хэрэглэх; 11.1.10. тээвэрлэлт үйлдэх огноо, маршрут, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийг бусдад дамжуулах. 11.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөж хориглосон үйл ажиллагаа эрхлэхгүй байх. Арван хоёр. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэлтэд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага. 12.1. Цагдаагийн байгууллагаас тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн зөвшөөрөл олгох болон зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд захиргааны хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. 12.1.1. хууль тогтоомж түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас дагаж мөрдүүлэхээр гаргасан стандарт, дүрэм, журмыг сахиулах; 12.1.2. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг осол аюулгүй тээвэрлэх нөхцөл шаардлага, автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх; 12.1.3. хуулийн этгээдээс гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны зааварчилгааг батлуулан хэрэгжүүлж байгаа эсэх. 12.2. хуулийн этгээд нь үйл ажиллагааны тайлан, мэдээ, энэ журмын 4.4 дэх хэсэгт заасан дүгнэлтийг хагас бүтэн жилээр гаргаж жил бүрийн 06 сарын 01, 12 сарын 01-ний өдрөөс өмнө Цагдаагийн байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгжид
--	--	--	--	---

				хүргүүлж дүгнүүлэх бөгөөд хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно. 12.3. Цагдаагийн байгууллага нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, алба хаагч, тээврийн хэрэгслийн бүртгэл судалгаа, тээвэрлэлтийн маршрут, ачааны нэр төрөл, тоо хэмжээ, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаар мэдээлэл агуулсан зөвшөөрлийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн сантай байх бөгөөд сангийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг Мэдээлэл технологи, холбооны нэгж хариуцна. 12.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журмыг зөрчсөн, эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлэн зөвшөөрөл авсан тохиолдолд хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ. Учирсан хохирол нийгмийн хор аюул цаашид үүсэх үр дагаврыг тухайн байгууллага албан тушаалтан бүрэн хариуцна.
6	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох /Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 4.4/	Жолоодох эрхийн үнэмлэх, шинээр авах Жолоодох эрхийн үнэмлэх, нөхөн авах Жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа сунгуулах Жолоодох эрхийн үнэмлэх, Ангилал ахиулах Мэдээлэл зөрүүтэй засах Монгол улсын Олон улсын жолоодох эрхийн үнэмлэх захиалах (1жил) Монгол улсын Олон улсын жолоодох	Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний дүрэм”, Хөдөлмөрийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/171, А/496 дугаар хамтарсан тушаалаар баталсан	Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Дөрөвдүгээр бүлэг “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх” 15 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох 15.1. Дараах шаардлагыг хангасан иргэнд механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгоно: 15.1.1.тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий насанд хүрсэн; 15.1.2.тээврийн хэрэгсэл жолоодоход эрүүл мэндийн хувьд тэнцсэн; 15.1.3.тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад тэнцсэн. 15.2. Механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг жолоодох эрхийн үнэмлэхээр баталгаажуулна. 15.3. Жолоодох эрхийн болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг олгох, бүртгэх ажлыг цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэнэ. 15.4. Жолооны багшийн үнэмлэх олгох журам, жолооны багшийн үнэмлэхийн загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, жолоодох эрхийн үнэмлэх олгох журам, жолоодох эрхийн үнэмлэхийн загвар, үнийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална. 16 дугаар зүйл.Олон улсын жолоодох эрхийн үнэмлэх олгох 16.1.Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг Замын хөдөлгөөний тухай Венын конвенцод нийцүүлэн, жолоодох эрхийн үнэмлэхийг үндэслэн олгоно. 16.2.Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэхгүй. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм”:

		эрхийн үнэмлэх захиалах (2жил)	“Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/46, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах” /код-608/-аар зохицуулагдана.	2. Механикжсан тээврийн хэрэгслийн ангилал 2.1. Механикжсан тээврийн хэрэгслийг дор дурдсанаар ангилна: А-мотоцикл; В-жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй); С-“D” ангилалд хамаарагдахаас бусад бүх жин нь 3500 кг-аас их автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй); D-жолоочоос гадна наймаас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй); BE-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “B” ангиллын автомашин; CE-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “C” ангиллын автомашин; DE-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “D” ангиллын автомашин болон угсраа автобус, угсраа троллейбус; M-трактор, өөрөө явдаг машин механизм, тэдгээрийн чиргүүл буюу ажлын тоног төхөөрөмжтэй бүрэлдэхүүн. 2.2. “C”, “D”, “CE”, “DE” ангиллын тээврийн хэрэгслийг дор дурдсанаар дэд ангилна: C1-бүх жин нь 7500 кг-аас илүүгүй “C” ангиллын автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй); 2.3. D1-жолоочоос гадна арван зургаагаас илүүгүй хүний суудалтай “D” ангиллын автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй); C1E-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “C1” дэд ангиллын автомашин; D1E-бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй “D1” дэд ангиллын автомашин. 2.4. “A”, “B”, “C”, “M” ангилал болон “C1” дэд ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг арван найм, “D” ангилал болон “D1” дэд ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хорин нэгээс дээш насны хүнд олгоно. 2.5. “BE”, “CE”, “DE” ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн жолоодох эрхийг тухайн харгалзах “B”, “C”, “D” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий хүнд, түүнчлэн “C1E”, “D1E” дэд ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн жолоодох эрхийг тухайн харгалзах “C”, “D” ангилал буюу “C1”, “D1” дэд ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий хүнд олгоно. 2.5. “C”, “D” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх бүхий хүн нь тухайн харгалзах “C1”, “D1” дэд ангиллын тээврийн хэрэгслийг, мөн “CE”, “DE” ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн жолоодох эрх бүхий хүн нь тухайн харгалзах “C1E”, “D1E” дэд ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүнийг жолоодох эрхтэй байна. 2.6. Механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг холбогдох хууль, журмын дагуу олгоно. (Дэлгэрэнгүйг https://legalinfo.mn/mn/detail?lawId=208663) Хөдөлмөрийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/171, А/496 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”: Нэг. Нийтлэг үндэслэл
		Монгол улсын Олон улсын жолоодох эрхийн үнэмлэх захиалах (3жил)		

				1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр механикжсан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна. 1.2. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын стандартын шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага /цаашид “Жолооч бэлтгэх сургалтын байгууллага” гэх/ нь мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдуулан баталсан журмын дагуу бүртгүүлж, сургалтын үйл ажиллагааг энэхүү журмын дагуу эрхлэн явуулна. Хоёр. Жолооч бэлтгэх сургалтад элсүүлэх 2.1. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн жолооч бэлтгэх сургалтад суралцаж болно. 2.2. Энэ журмын 2.1-д заасан жолооч бэлтгэх сургалтад хамрагдах этгээд дор дурдсан материалыг бүрдүүлсэн байна. 2.2.1. иргэний үнэмлэх буюу түүнтэй адилтгах баримт бичиг; 2.2.2. эрх бүхий эрүүл мэндийн байгууллагын тээврийн хэрэгсэл жолоодоход тэнцэх талаарх үзлэгийн хуудас; 2.2.3. ангилал өөрчлөх /нэмэх/ тохиолдолд жолооны үнэмлэх; 2.3. Жолоодлогын дадлагын сургалтад хамрагдах этгээд дараах шаардлагыг хангасан байна: 2.3.1. тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад орох үед Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрх бүхий насанд хүрсэн байх; 2.3.2. "С" ангиллын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтад хамрагдах тохиолдолд "В" ангиллын тээврийн хэрэгслийг 3 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан байх; 2.3.3. "D" ангиллын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтад хамрагдах тохиолдолд "В" ангиллын тээврийн хэрэгслийг 6 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан байх; 2.3.4. "BE", "CE", "DE" ангиллын тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний жолооч бэлтгэх сургалтад хамрагдах тохиолдолд тухайн үндсэн ангиллын тээврийн хэрэгслийг 1 жилээс доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан байх; Гурав. Суралцагчийн эрх, үүрэг 3.1. Жолооч бэлтгэх сургалтад хамрагдах этгээд дор дурдсан эрхтэй байна. 3.1.1. онолын болон жолоодлогын дадлагын сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад бүрэн хамрагдаж, тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох мэдлэг, дадлага эзэмших; 3.1.2. онолын мэдлэгийг бие даан эзэмших; 3.1.3. сургалтын талаарх санал гомдлыг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний салбар нэгжид гаргах; 3.2. Жолооч бэлтгэх сургалтад хамрагдах этгээд дараах үүргийг хүлээнэ.
--	--	--	--	--

				3.2.1. жолоодлогын сургалтын хөтөлбөрт тогтоосон хуваарийн дагуу хамрагдах; 3.2.2. жолоодлогын сургалтад хамрагдах этгээд нь байгууллагын дотоод дүрэм болон гэрээг дагаж мөрдөх; Дөрөв. Жолооч бэлтгэх сургалтыг зохион байгуулах 4.1. Жолооч бэлтгэх сургалтад хамрагдах этгээд тухайн сургалтын байгууллагатай гэрээ байгуулна; 4.2. Жолооч бэлтгэх сургалтын байгууллагын стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргана. 4.3. Жолооч бэлтгэх сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. 4.4. Жолооч бэлтгэх сургалтын байгууллага нь онол болон дадлагын тухайн сэдвийн сургалтыг хуваарийн дагуу тогтмол явагддаг байхаар төлөвлөнө. 4.5. Сургалтын хөтөлбөрийн дагуу онолын мэдлэг, талбайн дадлага эзэмшсэн суралцагч замын хөдөлгөөнд оролцож, дадлага хийнэ. 4.6. Жолооч бэлтгэх сургалтын байгууллага нь онолын болон жолоодлогын дадлагын урьдчилсан шалгалт авч, тэнцсэн суралцагчид энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан жолоодох эрхийн шалгалтад орох үнэлгээний хуудас олгоно. 4.7. Үнэлгээний хуудас авсан этгээд 3 сарын хугацаанд жолоодох эрхийн шалгалтад орох эрхтэй. 4.8. Шалгалтыг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авахтай холбогдуулан баталсан журмын дагуу зохион байгуулах бөгөөд тэнцсэн эсэх талаарх мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтад тэмдэглэнэ. Тав. Бусад 5.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхдээ сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/46, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”: Нэг. Нийтлэг үндэслэл 1.1. Механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт /цаашид “шалгалт” гэх/ авах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна. 1.2. Шалгалтыг нийслэлд Цагдаагийн төв байгууллагын харьяа жолоодох эрхийн шалгалтын асуудал эрхэлсэн нэгжийн /цаашид “шалгалтын асуудал эрхэлсэн нэгж” гэх/, аймагт тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Замын цагдаагийн нэгжийн эрх бүхий алба хаагч /цаашид “шалгагч” гэх/ авна. 1.3. Шалгалтыг авахдаа мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн байгууллага болон төрийн бус байгууллагаас мэргэшсэн ажилтанг оролцуулж
--	--	--	--	--

				болно. 1.4. Шалгалтын асуудал эрхэлсэн нэгж нь механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр удирдан зохион байгуулна. 1.5. Шалгагч нь Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн чадамжийн үнэлгээ, баталгаажуулалтын ажилтан бэлтгэх модулын сургалтад хамрагдсан байна. Гурав. Жолоодох эрхийн шалгалтад орох нөхцөл 3.1. Шалгалтад орох иргэн/цаашид “шалгуулагч” гэх/дор дурдсан нөхцөлийг хангасан байна: 3.1.1.Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрх бүхий насанд хүрсэн; 3.1.2. эрүүл мэндийн байгууллагаас гаргасан тээврийн хэрэгсэл жолоодоход “тэнцэнэ” гэсэн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт /цаашид “эрүүл мэндийн үзлэгийн хуудас” гэх/ авсан; 3.1.3. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журмын дагуу жолоодох эрхийн шалгалтад орох үнэлгээний хуудас авсан; <i>Тайлбар: Дээрх заалт нь гадаад улсаас олгогдсон жолоодох эрхийн үнэмлэхтэй хүн шалгалтад орох тохиолдолд хамаарахгүй.</i> 3.1.4. “С” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад орох тохиолдолд “В” ангиллын тээврийн хэрэгслийг 3 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан; 3.1.5. “D” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад орох тохиолдолд “В” ангиллын тээврийн хэрэгслийг 6 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан; 3.1.6. “E” ангиллын нэмэлт эрх авах шалгалтад орох тохиолдолд тухайн үндсэн ангиллын тээврийн хэрэгслийг 6 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан. 3.2. Шалгуулагч нь дараах материалыг бүрдүүлсэн байна: 3.2.1. иргэний үнэмлэх буюу түүнтэй адилтгах баримт бичиг; 3.2.2. эрүүл мэндийн үзлэгийн хуудас; 3.2.3. энэ журмын 3.1.3-т заасан үнэлгээний хуудас; 3.2.4. цээж зураг /өнгөт 4х6 см хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан/ 1 хувь; 3.2.5.жолоодох эрхийн үнэмлэх /ангилал нэмүүлэх болон гадаад улсаас олгогдсон жолоодох эрхийн үнэмлэхтэй хүн шалгалтад орох тохиолдолд/. 3.3. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага нь шалгалтад орох иргэний мэдээллийг шалгалтад орохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө журмын 2.2 дахь хэсэгт заасан цахим санд илгээсэн байна. 3.4. Энэ журмын 4.5.5-д заасны дагуу онолын шалгалт өгөх, мөн 4.8, 4.9-д заасны дагуу дахин шалгалт өгөх иргэн нь шалгалтад орох хүсэлтээ 7-оос доошгүй хоногийн
--	--	--	--	---

				өмнө журмын 2.2 дахь хэсэгт заасан цахим санд илгээсэн байна. Дөрөв. Жолоодох эрхийн шалгалтын төрөл, агуулга Жолоодох эрхийн шалгалт нь онолын, дадлагын гэсэн хоёр төрөлтэй байна. 4.2. Онолын шалгалтаар тухайн ангиллын тээврийн хэрэгслийн жолоочийн эзэмшсэн байвал зохих онол, эрх зүйн мэдлэгийг шалгана: 4.2.1. Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 4.2.2. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм; 4.2.3. тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох онол; 4.2.4. зам тээврийн осолд өртсөн хүнд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж. 4.3. Онолын шалгалтыг ерөнхий мэдлэгийн 20 асуулт бүхий тест болон нэмэлт мэдлэгийн 10 асуулт бүхий тестээр авна. Нэмэлт мэдлэгийн тест нь “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслийн жолоочийн эзэмшсэн байвал зохих мэдлэгийг шалгахад чиглэсэн байна. 4.4. Дадлагын шалгалтаар тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох ур чадварыг шалгана. Дадлагын шалгалтыг замын хөдөлгөөнд /цаашид “замын хөдөлгөөний жолоодлогын шалгалт” гэх/, эсвэл жолоодлогын тусгай талбайд /цаашид “талбайн жолоодлогын шалгалт” гэх/ авна. 4.5. Шалгуулагч нь жолоодох эрхийн шалгалтыг дор дурдсан төрөл, агуулгаар өгнө: 4.5.1. “B” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах тохиолдолд онолын шалгалтыг ерөнхий мэдлэгийн тестээр, дадлагын шалгалтыг замын хөдөлгөөнд; 4.5.2. “C”, “D” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах тохиолдолд онолын шалгалтыг нэмэлт мэдлэгийн тестээр, дадлагын шалгалтыг талбайд; 4.5.3. урьд нь аль нэг ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх авч байгаагүй хүн “A” буюу “M” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах тохиолдолд онолын шалгалтыг ерөнхий мэдлэгийн тестээр, дадлагын шалгалтыг талбайд; 4.5.4. “E” ангиллын нэмэлт эрх авах буюу эсвэл аль нэг ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй хүн “A” буюу “M” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх нэмж авах тохиолдолд зөвхөн талбайн шалгалт; 4.5.5. гадаад улсаас олгогдсон жолоодох эрхийн үнэмлэхтэй хүн шалгалтад орох тохиолдолд онолын ерөнхий мэдлэгийн шалгалт. 4.6. Шалгалт тус бүрийг “Тэнцсэн”, “Тэнцээгүй” гэсэн хоёр үнэлгээгээр дүгнэнэ. 4.7. Онолын болон дадлагын шалгалтад хамрагдвал зохих шалгуулагч эхлээд онолын, дараа нь дадлагын гэсэн дарааллаар шалгуулна. Онолын шалгалтад тэнцээгүй тохиолдолд дадлагын шалгалтад орохгүй. 4.8. Шалгуулагч нь тэнцээгүй шалгалтаа дахин өгөх эрхтэй бөгөөд шалгалт хоорондын хугацаа 7 хоногоос багагүй байна. 4.9. Шалгуулагч онолын шалгалтад тэнцсэнээс хойш 6 сарын хугацаанд дадлагын шалгалтад тэнцээгүй буюу хамрагдаагүй тохиолдолд онолын шалгалтад тэнцсэн
--	--	--	--	--

				үнэлгээ хүчингүй болно. Энэ тохиолдолд шалгалтыг дахин өгнө. 4.10. Дадлагын шалгалтыг тухайн эрх олгох ангиллын тээврийн хэрэгсэл дээр явуулна. "В" ангиллын жолооч бэлтгэх сургалтад хамрагдсан шалгуулагчаас хүсэлт гаргасан тохиолдолд автомат хурдны хайрцаг бүхий тээврийн хэрэгслээр дадлагын шалгалтыг авч болно. /Энэ тохиолдолд жолоочийн үнэмлэхийн тусгай тэмдэглэлд "автомат" гэсэн тэмдэглэл хийнэ./ 4.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс жолоодох эрх олгох мэргэжлийн шалгалт авах тохиолдолд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 —д заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр шалгалтыг авч, жолоочийн үнэмлэхийн тусгай тэмдэглэлд тусгана. /дэлгэрэнгүйг https://legalinfo.mn/mn/detail?lawId=209205&showType=1/ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах" /код-608/ 608.1. ЗОРИЛГО Тээврийн хэрэгслийн жолоодох эрх болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэх олгох,замын хөдөлгөөний талаар зарим зөвшөөрөл олгох,жолоочийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 608.3.НЭР ТОМЬЁО Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: "Жолоочийн бүртгэл, мэдээллийн сан"-Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т зааснаар; "Жолоочийн бүртгэл, мэдээллийн систем"-тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн үнэмлэх болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэх авсан хүний талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл дамжуулах, мэдээллийг статистик мэдээний болон судалгааны хэлбэрээр боловсруулах программ хангамж, мэдээллийн сүлжээ, техник, тоног төхөөрөмжийг; "Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээ"-Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /код 701/ журам"-ын 701.3 дугаар зүйлд зааснаар; "Үнэлгээний хуудас"-Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/171, А/496 дугаар тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам"-ын 4.6 дахь хэсэгт зааснаар; "Батламж"-тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх сургалтын байгууллагаас ирүүлсэн жолоочийн лавлагаа, мэдээлэл бүхий хэвлэмэл хуудсыг; "Жолоодох эрхийн үнэмлэхийн бүртгэлийн хуудас"-Замын хөдөлгөөний тухай Венын конвенцын гишүүн улсын жолоочийн үнэмлэхийг Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхээр солих, Замын хөдөлгөөний тухай Венын конвенцын гишүүн бус улсын жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхээр солих,Олон Улсын жолоочийн үнэмлэх авах эсэхийг бүртгэх, шинээр
--	--	--	--	---

				жолоодох эрх авсан, тээврийн хэрэгслийн ангилал ахиулсан, Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэх нөхөн авах, Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа сунгах, Жолоодох эрхийн үнэмлэхийн зөрүүтэй мэдээлэл засуулах зэрэг бичмэл хуудсыг; Тайлбар: “Жолоодох эрхийн үнэмлэхийн бүртгэлийн хуудас”-ыг бүртгэхэд иргэн, хуулийн этгээдээс ямар нэгэн төлбөр, хураамж авахыг хориглоно. “Шалгагч”-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны А/46, А/09 дүгээр тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн шалгалт авах журам”-ын 1.2 дахь хэсэгт зааснаар; “Замын хөдөлгөөн” -Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.5-д зааснаар. 608.6. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ТОХИОЛДЛУУД, АНХААРАХ ЗҮЙЛ 608.6.1. Замын хөдөлгөөнд саад учруулахаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл: а/замын хөдөлгөөний чиглэл, урсгалыг өөрчлөх нь өдөр тутмын замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлнө. Иймд Замын цагдаагийн алба нь зөвшөөрөл олгох ажиллагаанд болгоомжтой хандах хэрэгтэй. Зорчих хэсгийг нарийсгах, хөдөлгөөнд саад учруулахаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгоход замын хөдөлгөөний ослоос сэргийлэх арга хэмжээний талаар энэ чиглэлийн мэргэжилтэн, албан хаагчидтай зөвшилцөнө; б/зөвшөөрлийг олгосон тохиолдолд замын хөдөлгөөний чиглэл, урсгалыг өөрчлөх, зам, зорчих хэсгийг нарийсгах болон хөдөлгөөнд саад учруулахаар үйл ажиллагаа явуулах болсон талаар иргэд, хуулийн этгээдэд урьдчилан анхааруулж, мэдэгдэж, зарлана; в/зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж, энэ тухай зарлах үүргийг мөн адил хүлээнэ. 608.6.2. Замын тэмдэг, тэмдэглэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл шинээр тавих, хурааж авах, өөрчлөх зөвшөөрөл а/замын тэмдэг, тэмдэглэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл шинээр тавихад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийн нэгдүгээр хавсралтаар тогтоосон хэм хэмжээнд заасан шаардлагыг зөрчихгүй байх бодлого баримтална. Замын тэмдэг, тэмдэглэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл шинээр тавих, өөрчлөх зөвшөөрөл олгосон нь урьдын тэмдэг, тэмдэглэл, техник хэрэгслийг хураан авах үндэслэл болно. 608.6.3. Төмөр замын гарам байгуулах, өөрчлөх, хөдөлгөөн зогсоож засварлах зөвшөөрөл: а/энэ зөвшөөрөл нь саналын хэлбэртэй байна. Төмөр замын гармыг нээх, хаах, ашиглах, хамгаалалтын дохио, тэмдэг, төхөөрөмжөөр тоноглох, засварлах журам, төмөр замын гармын зэрэглэл тогтооход цагдаагийн байгууллагын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгжээс санал өгөх тухай зохицуулалтыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 606-д заасан
--	--	--	--	---

				журмаар шийдвэрлэнэ. 608.6.4. Нийтийн болон тусгай үйлчилгээний тээврийн хэрэгслийн явах чиглэл, зогсох буудлыг шинээр тогтоох буюу өөрчлөх зөвшөөрөл:а/нийтийн болон тусгай үйлчилгээний тээврийн хэрэгслийн явах чиглэл, зогсох буудлыг шинээр тогтоох буюу өөрчлөх зөвшөөрөл олгохдоо дагалдах тэмдэглэл, тэмдэглэгээ, техник хэрэгслийг байрлуулах, явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг анхаарна. 608.6.5. Замын хөдөлгөөнд саад болох биеийн тамирын уралдаан тэмцээн, жагсаал, тоглолт зэрэг үйл ажиллагаа явуулах:а/биеийн тамирын уралдаан тэмцээн, жагсаал, тоглолтын эхлэх, дуусах хугацаа, чиглэлийг урьдчилан судалж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Замын түгжрэл удаан хугацаанд үргэлжилдэг гараг, цагуудад дээрх арга хэмжээ явагдахаар бол өөр өдөр, гараг сонгох саналыг зохион байгуулагчдад санал болгоно. 608.6.6. Тээврийн хэрэгсэл тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх зөвшөөрөл олгох: а/Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам”-ын 2.1-д заасан байгууллагаас ирүүлсэн тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх тухай хүсэлтийг цагдаагийн төв байгууллагын Бүртгэл хяналт хариуцсан нэгж хүлээж авна; б/цагдаагийн төв байгууллагын Бүртгэл хяналтын нэгж нь байгууллагын хүсэлт, үндэслэлийг судлан, хянан үзэж саналаа маягт /ЦБҮАЖ №608.666/-ын дагуу ажлын 3 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэх асуудлыг цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ; в/цагдаагийн төв байгууллагын даргаас тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх зөвшөөрлийг олгосон тохиолдолд цагдаагийн төв байгууллагын Бүртгэл хяналт хариуцсан нэгж нь тээврийн хэрэгслийн гэрчилгээнд тэмдэглэл хийнэ. Тэмдэглэлд тусгай дуут болон гэрлэн дохиог хэрэглэх хугацааг тавьж, гарын үсэг зурж, дардас дарж баталгаажуулна; г/зөвшөөрөл олгох үндэслэлгүй тохиолдолд энэ тухай үндэслэлийг дурдсан хариуг тухайн байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ;д/цагдаагийн төв байгууллагын Бүртгэл хяналтын нэгж нь тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх зөвшөөрөл олгосон тээврийн хэрэгслийн бүртгэл, хөдөлгөөний талаарх мэдээллийг “Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх /код 703/ заавар”-ын хавсралт /маягт 5122/-ын тэмдэглэл хэсэгт бичилт хийж санд тухай бүр оруулна;е/цагдаагийн төв байгууллагын Бүртгэл хяналтын нэгж нь тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх эрх бүхий байгууллагын жолооч нарт тэдгээрийг хэрэглэхтэй холбоотой богино хугацааны сургалтыг эрхлэн гүйцэтгэнэ; Сургалтын хөтөлбөрийг цагдаагийн төв байгууллагын Бүртгэл хяналтын нэгжийн саналыг үндэслэн цагдаагийн төв
--	--	--	--	---

				байгууллагын Дэд дарга батална. 608.7.ЗӨВШӨӨРӨЛ ӨГӨХӨД БАРИМТЛАХ ЗАРЧИМ а/зөвшөөрөл олгосноор замын хөдөлгөөний аюулгүй байдалд учирч болох хүндрэл, үр дагаврыг урьдчилан тооцоолсон байна; б/зөвшөөрөл олгох эрх нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгжийн эрх бүхий субъектэд хадгалагдана; в/хуульд заасан үндэслэлийг чанд мөрдөнө; г/хүний эрх зөрчигдөх, хязгаарлагдах эсэх талаар судална; д/өөрчилсөн чиглэлийн дагуу замын хөдөлгөөнийг зохицуулах арга, ажиллагааны туршлага, нөөц бололцоо байгаа эсэхийг тодорхойлно.
--	--	--	--	---

Холбогдох албан тушаалтан: ЦЕГ-ын Зөвшөөрөл, үйлчилгээний төвийн Хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Бүүвэйбаатар /88120802/, /Buuwei17@gmail.com/

ЦЕГ-ЫН ЗӨВШӨӨРӨЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ